



NSW мужийн Боловсролын Яам

NSW мужийн улсын сургуульд Year 7 ангид шилжин суралцах тухай

Та хүүхдээ Year 6-аас Year 7 ангид дэвшин суралцуулахын тулд онлайнаар өргөдөл гаргана уу.

Таны хүүхдийн харьяа сургууль

NSW мужийн ихэнх улсын сургуулиуд элсэлт авах тодорхой заасан бүсүүдтэй байдаг ба ингэснээр сургуулийн насны бүх хүүхдүүд улсын сургуульд буюу харьяа сургуульдаа орох боломжтой болдог.

Таны хүүхдийн байнгын оршин суугаа хаягаар харьяа сургуулийг нь тодорхойлно. education.nsw.gov.au/school-finder вэбсайт дах The School Finder (Сургууль хайгч) хэрэгслийг ашиглан харьяа сургуулийнхаа байршлыг тодорхойлж болно.

NSW мужийн ихэнх эцэг эх, асран хамгаалагчид хүүхэддээ сайн боловсрол олгохоор харьяа сургуулийг сонгодог. Боловсролын Яамны онлайн элсэлтийн систем нь сурагчдыг ахлах сургуульд шилжин суралцахад нь дэмжлэг үзүүлдэг.

Харьяа сургуулиуд ур чадварын бүхий л түвшинд сурагчдад боловсрол олгодог. Үүнд оюуны потенциал өндөртэй эсвэл гоц ухаантай сурагчдад тохирсон хөтөлбөр мөн нэмэлт сургалт болон давтлага хэрэгтэй сурагчдад зориулсан хөтөлбөрүүд гэх мэт. Мөн түүнчлэн тэд хичээлээс гадуурх өргөн сонголт бүхий хөтөлбөрүүдийг санал болгодог.

Олон кампустай коллежууд (ахлах сургуулиуд) нь хэд хэдэн сургууль эсвэл кампусуудтай байх ба тухайн сургууль эсвэл кампус бүр нь тодорхой чиглэлээр төрөлжсөн байдаг. Тухайлбал, бага ангийн кампусууд (Years 7-9 эсвэл 7-10), ахлах ангийн кампусууд (Years 10-12 эсвэл 11-12), академик сонгоны кампусууд, холимог хүйст сургалтын кампусууд, мөн нэг хүйст сургалтын кампусууд гэх мэт.

Төвийн сургуулиуд гэдэг нь хөдөө орон нутаг болон алслагдсан дүүргийн хүүхдүүдэд боловсрол олгох зорилгоор Kindergarten ангиас Year 12 хүртэлх бүх ангиуд нэг сургуульд төвлөрсөн байдаг. Ихэнх төвийн сургуулиуд өөр сургуулийн багш сурагчдыг технологийн тусламжтайгаар холбодог ба ингэснээр олон төрлийн сэдвээр хичээл орох боломжтой болдог. Мөн хичээлээс гадуурх хөтөлбөрүүд санал болгодог.

Хэрэв та онлайнаар өргөдөл гаргах боломжгүй эсвэл хүсэхгүй байгаа бол энэ товхимолын 5-р хуудаснаас эхлэх маягтыг бөглөнө үү. Бөглөсөн маягтыг хүүхдийнхээ бага сургуульд буцааж өгнө үү.

Дэлгэрэнгүй мэдээлэлтэй доорх холбоосоор орж танилцана уу
education.nsw.gov.au/public-schools/going-to-a-public-school/enrolment/high-school-enrolment



Бусад сургуулийн сонголтууд

Та хүүхдээ харьяа бус сургуульд элсүүлэх шалтгаантай байж болох юм.



Харьяа бус (эсвэл заасан бүсээс гадуурх) сургуулиуд

Тодорхой бүсээс элсэлт авдаг сургуулиуд нь орон тооны хязгаартай байдаг – сургуулийн байнгын багтаамжаас шалтгаалан элсэж орох сурагчдын тоо хязгаартай. Орон тооны хязгаараас хамааран харьяа-бус элсэлт хүлээн авах эсвэл авахгүй байх нь шийдэгдэнэ. Зарим сургуулиуд орон тооны хязгаар дотроо харьяа элсэлтийн нөөц түвшинг тогтоодог ба энэ нь жилийн дундуур орж ирэх харьяаллын сурагчдад орон тооны нөөц гаргаж байгаа хэрэг юм.

Орон тооны хязгаар давсан эсвэл дөхөж буй сургуулиуд харьяа-бус сурагчдыг хүндэтгэх шалтгаангүй бол элсүүлэхгүй.

Гэхдээ элсэлтийн нөөц түвшингээс гадна орон тоо байгаа сургуулиуд харьяа-бус сурагчдыг элсүүлэх боломжтой юм.

Хэрвээ харьяа-бус элсэлтийн хэрэгцээ нь тухайн сургуулийн элсэлтийн нөөц түвшингээс гаднах орон тоон хэмжээнээс давсан тохиолдолд сургууль элсэлтийн тодорхой шалгуур боловсруулж, харьяаллын бус сурагчдыг элсүүлэх сонгон шалгаруулалтын комисс байгуулах ёстой.

Төрөлжсөн сургуулиуд

Төрөлжсөн сургуулиуд нь дунд боловсрол олгоходоо тодорхой нэг сонирхол эсвэл авьяасыг илүү хөгжүүлэхэд анхаардаг. Төрөлжсөн сургуулиуд нь бүтээлч урлаг, тоглолтын урлаг болон дүрслэх урлаг, гадаад хэл, технологи (тухайлбал далайн технологи болон орон нутгийн технологи), хөдөө аж ахуй болон спорт зэргээр сурагчдыг хөгжүүлэхэд зориулсан байдаг.

Зарим төрөлжсөн сургуулиуд элсэлт авахдаа тоглолт үзүүлэх эсвэл сонгон шалгаруулалтанд орох шалгуур тавьдаг.

Нэмэлт давтлагын ангиуд

Зарим дунд сургуулиуд хөдөлмөрийн бэрхшээлтэй хүүхдүүдэд туслах зорилгоор тэдний хэрэгцээ шаардлагад тохируулсан нэмэлт давтлагын ангиудтай байдаг. Таны хүүхдийн бага сургуулийн захирал таны сонголт, хүүхдийн тань сургалтын нэмэлт хэрэгцээ, шаардлага болон харьяа мэргэжлийн үйлчилгээнд ойр байх зэргийг харгалзан хүүхдэд тань зөв сургууль сонгоход туслах болно.

Нэмэлт давтлагын ангийн элсэлт сонгон шалгаруулах журмаар явагддаг.

Академик сонгоны сургуулиуд

Бүрэн болон хагас академик сонгоны сургуульд элсэх шалгаруулалтын процесс тухайн сурагч Year 5 ангид байхаас эхлэх ба энгийн элсэлтийн процессоос илүү урт хугацаа шаарддаг.

Өргөдлийн маягт зөвхөн онлайнгаар байх ба хугацаа хэтэрсэн өргөдлийг авахгүй гэдгийг анхаарна уу.

Академик сонгоны сургуулиудын жагсаалт болон элсэлтийн үйл явцын талаарх нарийн мэдээллийг доорх вэбсайтаас авах боломжтой:

<https://education.nsw.gov.au/public-schools/selective-high-schools-and-opportunity-classes>

Эрчимжүүлсэн Англи Хэлний Төвүүд

<https://education.nsw.gov.au/school-finder> вэбсайт дах Сургууль Хайгч хэрэгслийг ашиглан Эрчимжүүлсэн Англи Хэл ордог дунд сургуулиудын байршлыг тогтоож болно.

Та гэрийн хаяг эсвэл шуудангийн кодоо оруулан харьяа сургуулийнхаа газрын зураг дээрх байршлыг хайх ба “Nearby schools” гэдэг хэсэг дээр Intensive English Centre гэсэн товчийг сонгоно.

Нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл харьяа бага сургуулийн захирал, эсвэл сонгосон дунд сургуулийн захиралтай нь холбогдоорой.

Хэрвээ танд орчуулагч хэрэгтэй бол **Утсан Орчуулгын Үйлчилгээний** 131 450 руу залган өөрийн хэл дээрх орчуулагчийг хүсээрэй. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.

Бүртгүүлэх Хүсэлт бөглөх

Та тухайн харьяа сургуулийнхаа болон/эсвэл хамгийн ихдээ 3 харьяаллын бус сургуульд Бүртгүүлэх Хүсэлтийн анкетийг бөглөн хүүхдээ аль сургуульд оруулах хүсэлтэй байгаагаа илэрхийлж болно.

Таны хүүхдийг Year 7 ангид элсүүлэх процесс нь гурван үе шаттай болно:

1-р шат: Сонгосон улсын сургуульдаа хуваарь авахын тулд Бүртгүүлэх Хүсэлтийг бөглөх

Энэхүү анкетийг дараа жил NSW мужийн улсын сургуульд Year 7 ангид элсэх хүсэлтэй бүх сурагчдын эцэг эх болон асран хамгаалагч нар бөглөх ёстой.

NSW муж улсын бага сургуульд элсэн суралцаж буй сурагчдын тухайд та өөрийн сонирхож буй сургуульд хүүхдээ элсүүлэх хүсэлтээ онлайн аар бөглөж эсвэл хавсаргасан цаасан маягтыг бөглөж, хүүхдийнхээ бага сургуульд буцааж өгөх боломжтой. Хэрэв таны хүүхэд улсын бага сургуульд суралцдаггүй бол өөрийн хүсэлтээ онлайн аар бөглөх буюу цаасан маягтыг бөглөн хүүхдийнхээ элсэх гэж буй NSW муж улсын дунд сургуульд өгч болно.

Хүсэлт хүлээн авах хамгийн сүүлийн өдөр эсвэл түүнээс өмнө Бүртгүүлэх Хүсэлтийг бөглөн өгөх ёстой.

2-р шат: Элсэх өргөдөл бөглөх

Таны хүүхэд сургуулиас хуваарь авсны дараа NSW мужийн улсын сургуульд Элсэх өргөдөл бөглөх хэрэгтэй болдог. Үүнийг 2-р улирал эсвэл 3-р улиралд тань руу илгээдэг.

Өргөдлийг онлайн аар бөглөх эсвэл 2 эсвэл 3-р улирлын үеэр танд илгээсэн цаасан маягтыг бөглөж болно.

Энэхүү өргөдөл дээрх бүх мэдээллийг бөглөн аль болох хурдан буцаан илгээгээрэй.

Тухайн сургуулийн захирал таны элсэх өргөдлийг харгалзан зөвшөөрснөөр элсэлтийн эцсийн шийдвэр гарна. Захирал нэмэлт мэдээлэл авахаар тантай холбогдож магадгүй.

Таны хүүхэд элсэлтэнд тэнцсэн эсвэл тэнцээгүйг баталсан захиа эсвэл и-мэйлийг та хүлээн авах болно.

3-р шат: Шинэ сургуультайгаа танилцах

Сургуульд элссэн тухай захиа хүлээн авсны дараа хүүхдээ Year 7 ангид шилжин суралцахад нь туслах нэг чухал зүйл бол шинэ сургуультайгаа танилцах юм.

Тухайн сургууль шилжилтийн арга хэмжээг болон дараа жил нь Year 7 ангид элсэж байгаа сурагчдад зориулан танилцах өдрийг зохион байгуулах болно. Энэхүү танилцах өдөр нь ихэвчлэн 11 сарын сүүл/12-р сарын эхээр болдог ба эцэг эх, асран хамгаалагч нар ч уригддаг. Энэ өдөр хүүхдүүд дунд сургуульд үзэх хичээл болон сэдвүүд, багш нар, анги танхимууд болон сургуулийн журамтай танилцах бөгөөд хамт суралцах сурагчидтай ч танилцах боломж олддог.

Шинэ сургуулиас танд танилцах өдрийн тов, дүрэмт хувцасны тухай мэдээлэл, сургууль руу зорчих сонголтуудын талаар болон бусад чухал мэдээллүүдийг хүргэх болно.

Хэрвээ танд дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй бол тухайн сургуулийн захиралтай нь холбогдоорой. Хэрвээ танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагчийг хүсээрэй. Оператор тухайн шугамд таны яриаг орчуулах орчуулагчийг холбох болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.

Таны хүүхдэд нэмэлт давтлага олгоход шинэ сургуульд туслах мэдээлэл

Та хүүхдийнхээ сургалтын нэмэлт давтлага авах шаардлагатай тухайг шинэ сургуульдаа мэдээлэх нь чухал юм. Мөн хүүхдийнхээ ямар нэгэн харшил эсвэл бусад эрүүл мэндийн нөхцөл байдлыг сургуульдаа мэдэгдэх зайлшгүй шаардлагатай.

Үүнд таны хүүхэд анафилакс, астма, чихрийн шижин эсвэл эпилепси оноштой эсэх мэдээллүүд орох ба гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй.

Хэрвээ таны хүүхэд анафилаксийн эрсдэлтэй гэж оношлогдсон бол эмчийн бөглөж, гарын үсэг зурсан хамгийн сүүлийн ASCIA Action Plan for Anaphylaxis бичгийг хүүхдийнхээ шинэ сургуульд өгөөрэй.

Сургууль ASCIA action plan бичгээс гадна төлөвлөгөөнд заасан яаралтай үед авах арга хэмжээнд ашиглах адреналины авто-тариурыг таниас шаардана. Сургуульд адреналины авто-тариур олгохдоо хугацаа нь дуусах өдрийг шалгах хэрэгтэй ба хугацаа дуусахаас нь өмнө шинийг олгох хэрэгтэй.

Бүртгүүлэх Хүсэлтийг бөглөхөд тань туслах мэдээлэл

A Хэсэг

Энэхүү A Хэсэг дээр хүүхдийнхээ хувийн мэдээллийг оруулах ба мэдүүлэгтэй танилцан гарын үсгээ зурна.

B Хэсэг

B Хэсэг дээр таны хүүхдийн гэрийн хаяг дээр үндэслэн харьяа сургуулийн нэрийг тодорхойлсон байх ба таны хүүхэд харьяа сургуульдаа элсэх эрхтэй.

Хэрвээ та өөрийн харьяа сургуульдаа элсэх бол B Хэсэг дээр гарын үсгээ зуран заасан өдрөөс өмнө маягтыг буцаан илгээгээрэй.

Хэрвээ та хүүхдээ академик сонгоны сургуульд элсүүлэхээр өргөдөл өгчихсөн ба хэрвээ амжилтгүй бол харьяа сургуульд нь элсүүлэх хүсэлтэй тохиолдолд мөн адил B хэсэг дээр гарын үсгээ зуран он сар өдрөө тэмдэглэнэ.

С Хэсэг

Хэрвээ та бусад сургуулийн хуваарь авах хүсэлтэй бол **С Хэсэг** дээр сонирхож буй нийт 3 хүртэлх тооны сургуулийг сонголтын дарааллаар нь жагсаан бичнэ.

Та дараах сургуулиудаас хуваарилалт хүсч болох ба үүнд:

- төрөлжсөн сургууль
- нэмэлт давтлагын ангид (бага сургуулийнхаа захиралтай зөвлөлдөнө) элсэхдээ хүүхдийнхээ шаардлагад тохирсон нэмэлт давтлагын ангийг хүсэж өргөдөл гаргана
- харьяа-бус сургууль.

Төрөлжсөн сургуулиуд болон харьяа-бус сургуулийн сонгон шалгаруулалтанд нэмэлт өргөдөл гаргах шаардлагатай гэдгийг анхаараарай.

Хэрвээ та нэмэлт өргөдөл гаргах шаардлагатай эсэхээ сайн мэдэхгүй байвал тухайн сонирхож буй сургуультайгаа шууд холбогдоорой.

Хэрвээ та харьяа-бус сургуульд хуваарилалт хүсч байгаа бол нэг нэмэлт шатыг дамжих хэрэгтэй болно.

Хэрвээ харьяа-бус элсэлтийн хэрэгцээ нь тухайн сургуулийн элсэлтийн нөөц түвшингээс гаднах орон тоон хэмжээнээс давсан тохиолдолд сургуулиуд харьяа-бус элсэлтэндээ тодорхой шалгуур тавьдаг.

Хэрвээ та харьяа-бус сургуульд хуваарилалт авахыг хүсвэл яагаад харьяа-бус хуваарилалт хүсч буй шалтгаанаа бичээрэй. Тухайлбал:

- төрсөн ах, эгч, дүү нь тухайн сургуульд сурдаг
- тухайн сургуульд байршил ойр эсвэл очих боломж их
- нэг хүйсийн сургуульд сурах боломж
- эрүүл мэндийн шалтгаанууд
- хүүхдийн хичээлийн дараах болон өмнөх хараа хяналт болон аюулгүй байдал
- тухайн сургуульд санал болгодог хичээлийн сэдэв эсвэл сэдвийн хослол
- хүндэтгэж үзэх нөхцөл байдал
- тухайн сургуулийн бүтэц болон зохион байгуулалт
- харьяа сургуулийн бүсийн зааг хязгаарлалтанд гарсан сүүлийн үеийн өөрчлөлтүүд.

Сургуулийн элсэлтийн комисс зөвхөн энэхүү анкет дээрх мэдээлэл болон таны илгээсэн бусад холбогдох бичиг баримт дээр үндэслэнэ.

Хэрвээ таны хүүхэд 1-р сонголтын сургуульдаа хуваарилалт аваагүй бол 2-р сонголтын сургуульд өргөдөл нь очих ба дараа нь 3-р сонголтын сургуульд гэсэн байдлаар явагдана.

Хэрвээ та сонгосон сургуулиудынхаа аль нэгэнд хуваарилалт авч чадаагүй бол тухайн сургууль танд мэдэгдэх болно. Сургууль таныг хүлээлгийн жагсаалтанд оруулан орон тоо гарахаар хуваарилалт санал болгоно хэмээн мэдэгдэж болно.

Хэрвээ таны хүүхэд сонирхсон сургуулиудынхаа аль нэгнээс хуваарилалт авсан тохиолдолд дараагийн сонголтын сургуулиудаас танд санал илгээхгүй болно.

Хэрвээ хүсэлт гаргасан аль ч сургуулиас нь хуваарилалт аваагүй бол таны хүүхэд **В Хэсэг** дээр заасан харьяа сургуульд хуваарилагдах ба тухайн сургууль таньд элсэх зөвшөөрөл олгосон тохиолдолд хүчинтэй болно.

Хэрвээ танд шударга бус хандсан эсвэл гарсан үр дүн үндэслэлгүй гэж үзвэл та дахин хянуулах өргөдөл гаргаж болно. Тухайн дунд сургуулийн захиралд бичгээр дахин хянуулах өргөдөл гаргана.

D Хэсэг

Хэрвээ та академик сонгоны сургуульд өргөдөл гаргасан бол энэхүү анкетийн **D Хэсэг** дээрх дөрвөлжинг чагтлах ба таны хүүхэд сонгоны сургуульд шалгараагүй байх тохиолдол гарч болох тул **B, C Хэсэг** эсвэл **E Хэсэг** дээрхийг мөн бөглөнө.

E Хэсэг

Хэрвээ та улсын сургуульд хуваарилалт авах шаардлагагүй бол E Хэсэг дээрхийг бөглөнө үү.

E Хэсэг дээрхийг бөглөснөөр таны хүүхдийг Year 7 ангид хуваарилахтай холбоотой NSW мужийн улсын сургуулийн бүх ажиллагаа дуусгавар болно.



Бүртгүүлэх Хүсэлт (Expression of Interest)

NSW мужийн улсын сургуулийн Year 7 ангийн хуваарилалт
Placement in Year 7 in a NSW Government school.

Энэхүү анкетийг англи хэл дээр бөглөнө үү

SRN

Зөвхөн ажилтны бөглөх хэсэг (эцэг эх/асран хамгаалагчид бөглөхгүй) (Office use only)

A. Сурагчийн мэдээлэл (A. Student information)

Эцгийн нэр
Family name

Өөрийн нэр
First given name

Middle (бусад) нэр/с
Middle (other) name/s

Хүйс
Gender

 Эр
Male Эм
Female

Төрсөн он сар өдөр
Date of birth

/ /

өдөр сар жил

Оршин суугаа хаяг (жишээ нь 1 High Street, Sydney, NSW, 2000) (Residential address)

Эцэг эх/асран
хамгаалагчийн нэр
Name of parent/carer

Утасны дугаар (гар)
Phone number (mobile)

Утасны дугаар (гэр)
Phone number (home)

Утасны дугаар (ажил)
Phone number (work)

И-майл хаяг
Email address

Сурагчийн одоогийн бага сургууль (Student's current primary school)

Мэдүүлэг (Declaration)

Энэхүү Бүртгүүлэх Хүсэлтэнд оруулсан мэдээллүүд миний мэдлэг, итгэл үнэмшлийн дагуу үнэн зөв, тодорхой ба бүрэн болохыг би мэдүүлж байна. Хэрвээ энэхүү өргөдөл дээрх мэдээлэл буруу эсвэл хуурамч гэдэг нь дараа илэрвэл өргөдлөөс гарсан үр дүн цуцлагдана гэдгийг би хүлээн зөвшөөрч байна. Энэхүү хуваарилалтын процессийн дараах элсэлт NSW мужийн улсын сургуульд Элсэх Өргөдлийг харгалзан зөвшөөрсний үндсэн дээр явагдана гэдгийг би ойлгож байна. (Application to Enrol in a NSW Government School)

Эцэг эх/асран хамгаалагчийн гарын үсэг (Signature of parent/carer)

Том үсгээр бичсэн нэр (Print name)

Он сар өдөр
Date

/ /

өдөр сар жил

B. Харьяа улсын сургуулийн хуваарилалт (B. Placement at local government school)

Таны харьяа сургууль (Your local school)

Хэрвээ та хүүхдээ энэ сургуульд элсүүлэхийг хүсвэл энэ хэсэг дээр гарын үсгээ зурна уу.

Эцэг эх/асран хамгаалагчийн гарын үсэг (Signature of parent/carer)

Он сар өдөр
Date

/ /

өдөр сар жил

Хэрвээ та дээр гарын үсгээ зурсан ба хүүхдээ зөвхөн энэ сургуульд элсүүлэх хүсэлтэй бол та энэхүү анкетийг бөглөж дууслаа.

C. Бусад улсын сургуульд элсүүлэх тухай харгалзан үзэх

C. Consideration to be given to placement at other government schools

Хэрвээ та хүүхдээ өөр улсын сургуульд элсүүлэхийг хүсч байвал хамгийн ихдээ гурван сургууль бичих боломжтой. Үүнд:

- **төрөлжсөн улсын сургууль.** Хэрвээ та хүүхдээ төрөлжсөн сургуульд хуваарилалт авахыг эсвэл улсын сургуулийн тусгай хөтөлбөрт хамруулахыг хүсч байгаа бол бага сургуулийнхаа захирлаас тусламж хүсэхийг зөвлөж буйг анхаарна уу.
- Нэмэлт давтлага шаардлагатай сурагчдад зориулсан **нэмэлт давтлагын ангиудтай** сургууль. Энэ нь хуваарилалтын комиссоор дамждаг гэдгийг анхаарна уу. **Хэрвээ та хүүхдээ нэмэлт давтлагын сургуульд хуваарилалт авахыг хүсч байгаа бол бага сургуулийнхаа захирлаас тусламж хүсэх хэрэгтэй.**
- бусад **харьяа-бус** улсын сургууль. Энэхүү хуудасны доор харьяа-бус хуваарилалт(ууд) хүсч буй шалтгаанаа бичнэ үү. (шаардлагатай бол 7-р хуудсыг бөглөнө үү) .

Би хүүхдэдээ дараах улсын сургууль/сургуулиудад хуваарилалт авахыг хүсч байна:

1-р сонголтын сургууль
Choice 1 school

2-р сонголтын сургууль
Choice 2 school

3-р сонголтын сургууль
Choice 3 school

Хэрвээ миний хүүхэд дээр дурдсан сургуулиудад хуваарилалт авч чадахгүй бол В Хэсэг дээр дурдсан бүсийн харьяа сургуульд хуваарилагдана гэдгийг би ойлгож байна.

Эцэг эх/асран хамгаалагчийн гарын үсэг (Signature of parent/carer)

Он сар өдөр
Date

<input type="text"/>	<input type="text"/>	/	<input type="text"/>	<input type="text"/>	/	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>
өдөр			сар			жил			

Зөвхөн бага сургуулийн захирал бөглөх хэсэг (Primary school principal use only)

Primary school principals may wish to include comments to assist secondary school principals make placement decisions. These comments should refer to the reasons given by parents and carers.

Signature of primary school principal

Date

<input type="text"/>	<input type="text"/>	/	<input type="text"/>	<input type="text"/>	/	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>
day			month			year			

Доорх мэдээллийг зөвхөн харьяа-бус сургуулиудад өргөдөл гаргаж байгаа тохиолдолд бөглөнө. Хэрвээ та төрөлжсөн сургуулиуд эсвэл нэмэлт давтлагын ангид өргөдөл гаргаж байгаа бол энэ хэсгийг бөглөх шаардлагагүй. Шаардлагатай тохиолдолд харьяа-бус сургуулиудын хуваарилалт авах хүсэлтэндээ нэмэлт мэдээлэл хавсаргаж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг 2 болон 3-р хуудаснаас авна уу.

1-р сонголтийн сургуулийн нэр
Name of Choice 1 school

Энэ сургуульд хуваарилалт авахыг хүссэн шалтгаанаа дурдана уу (сургуулийн элсэлтийн шалгуурыг харна уу).

C. (үргэлжлэл) C. (continued)

2-р сонголтийн сургуулийн нэр
Name of Choice 2 school

Энэ сургуульд хуваарилалт авахыг хүссэн шалтгаанаа дурдана уу (сургуулийн элсэлтийн шалгуурыг харна уу).

3-р сонголтийн сургуулийн нэр
Name of Choice 3 school

Энэ сургуульд хуваарилалт авахыг хүссэн шалтгаанаа дурдана уу (сургуулийн элсэлтийн шалгуурыг харна уу).

D. Академик сонгоны сургууль (D. Academically selective school)

 Би академик сонгоны сургуульд хуваарилалт авах өргөдөл гаргасан. Миний хүүхэд Сонгоны Дунд Сургуулиудын шалгалтанд орно.
I have submitted an application for placement in an academically selective school. My child will be sitting for the Selective High Schools test.

Таны хүүхэд дээрх сургууль(ууд)-с хуваарилалт авахгүй байх тохиолдол байж болох тул энэ анкетийн B Хэсэг, C Хэсэг эсвэл E Хэсэг дээрхийг бөглөнө үү.

E. Хуваарилалт шаардлагагүй (E. Placement not required)

Миний хүүхэд ирэх хичээлийн жилд NSW муж улсын сургуульд элсэн суралцахгүй гэдгийг би баталж байна. Би энэхүү баримт, мөн түүний доторх бичигдсэн хувийн мэдээллийг цуглуулах талаарх мэдээллийг уншиж ойлгосон болно. Миний хүүхэд доорх сургуульд элсэж орно*

I confirm that my child will not be seeking placement at a NSW Government school next year. I have read and understood the information about this submission including the collection of personal information. My child will be attending the following school.*

Эцэг эх/асран хамгаалагчийн гарын үсэг (Signature of parent/carer)

Он сар өдөр
Date

өдөр

сар

жил

*Энэхүү мэдээллийг заавал дурдах шаардлагагүй боловч бидэнд мэдэгдвэл талархах болно.

Хувийн Нууцыг Хадгалах Мэдэгдэл (Privacy Statement)

NSW муж улсын сургуулийн "Бүртгүүлэх Хүсэлт – Улсын сургуулийн 7-р ангийн элсэлт" гэсэн гарчигтай маягад орсон хувийн мэдээллийг NSW муж улсын сургуулиудын 7-р ангид тохирох сурагчдыг элсүүлэх зорилгоор цуглуулж байгаа болно. NSW муж улсын Боловсролын Яам (Яам гэх)-д өгсөн аливаа мэдээллийг уг муж улсын мэдээллийн нууцлалын тухай хууль тогтоомжид нийцүүлэн ашиглах, задруулах, хадгалах болно.

Нийгмийн эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн дагуу асран халамжлах үүрэг, мөн бусад хууль журмаар хүлээсэн чиг үүргээ биелүүлэхийн тулд, мөн Хамтын нөхөрлөлийн болон муж улсын санхүүжилтийн гэрээний дагуу мэдээлэл цуглуулах, тайлагнах шаардлагыг хангахын тулд Яамнаас сурагчийн зарим мэдээллийг өгөхийг шаарддаг. Уг мэдээлэл сурагчийн сурлагын үр дүнгийн үнэлгээ орж болно.

Мэдээллийг NSW мужийн болон Хамтын нөхөрлөлийн засгийн газрын агентлагууд болон мөн бусад байгууллагуудад дээр дурдагдсан зорилгоор, мөн хуулиар зөвшөөрөгдсөн эсвэл шаардсаны дагуу задруулж болно.

Мэдээллийг найдвартай цахим мэдээллийн санд хадгална. Та хүүхдийнхээ сургуультай холбогдон уг мэдээллийг олж авах эсвэл өөрчилж болно. Хэрэв таны хүүхдийн талаарх цуглуулсан мэдээлэл, түүнийг ашигласан, хэвлэн нийтлэсэн талаар санал гомдол байвал та сургуультай холбогдоно уу.

Хэрэв та шаардагдсан зарим мэдээллийг өгөхгүй байхаар шийдсэн бол энэ нь таны хүүхдийн элсэлт, сургуулийн сонголт, эсвэл хүүхдийнхээ боловсролын хэрэгцээг хангахад сөргөөр нөлөөлж болзошгүй гэдгийг анхаарна уу.

Таны хүүхдийг NSW муж улсын сургуульд элсэн суралцах үед цуглуулсан мэдээлэл, уг мэдээллийн нууцлалыг хэрхэн хамгаалдаг талаарх нэмэлт мэдээллийг Яамны вэб сайт эсвэл хүүхдийнхээ сургуулиас авах боломжтой. Та Яамны мэдээллийн нууцлалыг хадгалах журмын талаарх мэдээллийг дараах холбоосоор орж авах боломжтой: <https://education.nsw.gov.au/content/dam/main-education/about-us/rights-and-accountability/media/documents/privacy/collection-notice.pdf>

NSW мужийн улсын бага сургуульд одоогоор сурч байгаа сурагчдын хувьд анкетаа бөглөөд бага сургуульдаа буцааж өгөөрэй. NSW мужийн улсын бага сургуульд одоогоор бүртгэлгүй сурагчдын хувьд эцэг эх нь хүүхдээ элсүүлэхээр сонгосон NSW мужийн улсын дунд сургуульд анкетаа бөглөн өгөөрэй. Бүх Бүртгүүлэх Хүсэлтийг зарласан өдрөөс өмнө эсвэл тухайн өдөрт нь багтаан буцаан өгөх ёстой.



Бид энэ нутгийг Уугуул иргэдийн төрөлх эх нутаг гэдгийг хүлээн зөвшөөрч тэдэнд хүндэтгэл үзүүлж байна.

Say hello

 @NSWDepartmentofEducation

 @NSWEducation

 @NSWEducation

education.nsw.gov.au

© 2023 NSW Department of Education

GPO Box 33, Sydney NSW 2001 Australia

Phone: 1300 679 332

